



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/2/СТА-ААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn

Эрдэнэ сум

2021 он

Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга
бөгөөд тэргүүлэх аудитор: Т. Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: gan-ulzii@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа /Есөнхангай Аудит ХХК/

Утас: 99048891

Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021. 03. 19 № 1-6/306

танай _____-ны № _____-т

ДАГШИН-ЭРДЭНЭ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Ц.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	19,776,593.11	103,247,305.50
1.1.2	Дансны авлага	2,353,669.05	1,561,846.00
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		956,982.35
1.1.4	Бусад авлага		595,740.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	59,481,509.00	58,539,549.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	700,000.00	
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	8,225,800.00	9,510,150.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	90,537,571.16	174,411,572.85
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	378,939,639.00	363,432,129.34
1.2.2	Биет бус хөрөнгө	30,096,000.000	30,096,000.000
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	409,035,639.00	393,528,129.34
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	499,573,210.16	567,939,702.19
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	582,306.53	1,536,706.74
2.1.1.4	НДШ – ийн өглөг		1,245,280.00
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц/өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	582,306.53	2,781,986.74
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	582,306.53	2,781,986.74
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,074,650,681.00	1,089,477,842.00
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-575,659,777.37	-524,320,126.55
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	498,990,903.63	565,157,715.45
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	499,573,210.16	567,939,702.19

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	138,774,316.03	239,683,994.66
2	Борлуулалтын өртөг	39,844,098.00	31,069,800.00
3	Нийт ашиг(алдагдал)	98,930,218.03	208,614,194.66
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	115,025,076.45	134,534,321.56
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-406,005.67
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	-16,164,485.83	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-16,164,485.83	73,673,867.43
19	Орлогын татварын зардал		7,367,386.74
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-16,164,485.83	66,306,480.69
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-16,164,485.83	66,306,480.69
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	-16,164,485.83	66,306,480.69
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

						/төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,084,028,229.00				-938,191,106.51	500,346,394.49
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Залруулсан үлдэгдэл	1,084,028,229.00				-583,681,834.51	500,346,394.49
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					-16,164,485.83	-16,164,485.83
Өмчид гарсан өөрчлөлт	-9,377,548.00					-9,377,548.00
Зарласан ногдол ашиг						
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,074,650,681.00				-575,659,777.37	498,990,903.63
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-14,966,829.87	-14,966,829.87
Залруулсан үлдэгдэл	1,074,650,681.00				-590,626,607.24	484,024,073.76
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					66,306,480.69	66,306,480.69
Өмчид гарсан өөрчлөлт	14,827,161.00					14,827,161.00
Зарласан ногдол ашиг						
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,089,477,842.00				-524,320,126.55	565,157,715.45

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	178,202,530.00	244,091,892.05
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	137,646,335.56	124,022,000.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		120,000,000.00
	Бусад мөнгөн орлого	40,556,194.44	69,892.05
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	158,788,973.89	160,621,179.66
	Ажиллагчдад төлсөн	40,493,287.00	59,230,136.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	8,993,893.57	7,403,727.23
	Бараа материал худалдан авахад төлсөн	11,660,667.00	41,484,430.00
	Ашиглалтын зардалд төлсөн	6,479,937.68	6,746,265.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,432,432.00	1,799,090.00
	Хүүний төлбөрт төлсөн	2,450,000.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	18,289,943.24	15,820,431.43
	Даатгалын төлбөрт төлсөн	265,000.00	210,000.00
	Бусад мөнгөн зарлага	63,723,813.40	27,927,100.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	19,413,556.11	83,470,712.39
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	10,000,000.00	
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	10,000,000.00	
	Хүлээн авсан хүүний орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	11,500,000.00	
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	
	Төлсөн ногдол ашиг	0.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,500,000.00	0.00
4	Валютын ханшийн зөрүү	0.00	
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	19,413,556.11	83,470,712.39
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	363,037.00	19,776,593.11
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,776,593.11	103,247,305.50

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2020 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	ОРЛОГЫН НЭР ТӨРӨЛ				
1	Сувиллын орлого	130,340,000.00	227,300,000.00	96,960,000.00	74.39
2	Халуун ус	2,220,000.00	2,138,000.00	-82,000.00	-3.69
3	Зочид буудал, байр түрээс	1,800,000.00	4,262,000.00	2,462,000.00	136.78
4	Аялал жуулчлал	4,800,000.00	5,983,994.00	1,183,994.00	24.67
	ОРЛОГЫН ДҮН	139,160,000.00	239,683,994.00	100,523,994.00	72.24
	ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ				
1	Цалин	53,324,744.00	59,230,136.00	-5,905,392.00	-11.07
2	НДШ	6,468,559.00	7,403,767.00	-935,208.00	-14.46
3	Албан татвар, төлбөр хураамж	12,549,670.00	7,592,848.00	4,956,822.00	39.50
4	Томилолт	492,000.00	469,000.00	23,000.00	4.67
5	Бичиг хэрэг	321,000.00	1,002,100.00	-681,100.00	-212.18
6	Даатгал	260,370.00	210,000.00	50,370.00	19.35
7	Халаалт	4,269,000.00	4,268,880.00	120.00	0.00
8	Цахилгаан	4,560,000.00	4,193,331.00	366,669.0	8.04
9	Цэвэр ус	780,000.00	921,777.00	-141,777.00	-18.18
10	Сэлбэг засвар	1,465,000.00	2,751,800.00	-1,286,800.00	-87.84
11	Цэвэрлэгээ	100,000.00	328,000.00	-228,000.00	-228.00
12	Элэгдлийн зардал	43,638,998.00	40,111,098.00	3,527,900.00	8.08
13	Шатахуун	4,415,000.00	4,326,240.00	88,760.00	2.01
14	Зар сурталчилгаа	200,000.00	275,600.00	-75,600.00	-37.80
15	Тавилга эд хогшил	2,000,000.00		2,000,000.00	100.00
16	Хүнс	22,607,982.00	27,511,700.00	-4,903,718.00	-21.69
17	Бусад	500,000.00	5,007,844.56	-4,507,844.56	-901.57
18					
19	ЗАРДЛЫН ДҮН	157,952,323.00	165,604,121.56	-7,651,798.56	-4.84

/төгрөг/

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Эрдэнэ сумын Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Ц. Золжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бэлэн мөнгөний болон бараа материалын дэлгэрэнгүй тайлан гаргах, ажилтнуудын цалин хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос холбогдох хуулийн дагуу татвар шийтгэлийг суутгах, авлага өр төлбөрийн үлдэгдлийг баталгаажуулж байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 04-нөөс 2021 оны 03 дугаар сарын 09-ний хооронд Есөнхангай Аудит ХХК-ийн Т.Оюунтуяа, Ж.Оюунцэцэг, М.Одцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Орон нутгийн өмчит ААТҮГ статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

Байгууллагын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сувиллын мэргэжлийн үйл ажиллагаа
- Цайны газрын үйлчилгээ
- Зочид буудал, амралтын газар
- Байр орон сууц түрээслэх үйлчилгээ
- Хүнсний ногоо тариалалт
- Ус хуримтлуулан түгээх цэг

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогын 239.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 68.4 сая төгрөгөөр буюу 13.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	19.8	103.2	83.5
Авлага	2.4	3.1	0.7
Урьдчилгаа	0.7		0.7
Бараа материал	59.5	58.5	-0.9
Үндсэн хөрөнгө	378.9	363.4	15.5
Нийт хөрөнгийн дүн	499.6	567.9	68.4
Өр төлбөр	0.6	2.8	2.2
Эздийн өмч	499.0	565.1	66.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	499.6	567.9	68.4

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 103.2 сая төгрөг болж 83.5 сая төгрөгөөр өссөн нь сувиллын орлого нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 3.1 сая төгрөг болж 0.7 сая төгрөгөөр өссөн нь ажилтнуудаас авах авлага нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 363.4 сая төгрөг болж 15.5 сая төгрөгөөр буурсан нь өөрийн үйлдвэрлэсэн болон худалдан авсан хөрөнгө 25.1 сая төгрөгөөр нэмэгдэж, 4.5 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 40.6 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурч, 3.6 сая төгрөгийн данснаас хассан хөрөнгийн элэгдлээр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Эздийн өмч дансны үлдэгдэл 565.1 сая төгрөг болж 66.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны ашгаас шалтгаалжээ.

3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 18 дугаар тогтоолоор Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 139.2 сая төгрөгөөр, нийт зардлыг 157.9 сая төгрөгөөр, алдагдлыг 18.8 сая төгрөгөөр тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 239.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 165.6 сая төгрөгийн зардал гарган, 74.1 сая төгрөгийн үйл ажиллагааны ашигтай ажилласан байна. 2020 онд 480 сувилуулагчид үйлчлэхээр тооцсоноос 531 хүнд үйлчилж, сувилуулагчийн тоо 51-ээр нэмэгдсэн, мөн 1 даатгуулагчид олгох санхүүжилт оны өмнө 110 мянган төгрөгөөр тооцдог байсан ба ЭМДЕГ-аас 2020 оны 2-р сараас 1 даатгуулагчид олгох санхүүжилт 250 мянган төгрөг болж өссөнөөс орлого 72%-иар давж биелсэн байна.

Хүснэгт 1. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт	хүн	426	480	531	51	10.6
		Хүн	426	480	531	51	10.6
2	Нийт орлого	төг	138.8	139.2	239.7	100.5	72.2
	Үүнээс: Цэвэр борлуулалт						
3	Нийт зардал	төг	154.9	157.9	165.6	7.6	4.8
	Үүнээс:						
	а) Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		39.8	27.0	31.1	4.0	14.9
	б) Ерөнхий ба удирдлагын зардал		115.0	130.9	134.5	3.6	2.7
	в) Хөрөнгө оруулалт их засвар				17.0		
4	Цэвэр ашиг, алдагдал						
			-16.2	-18.8	74.1		

Нийт зардлын гүйцэтгэл 165.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 7.6 сая төгрөг буюу 4.8 хувиар хэтэрсэн байна. Энэ нь сувилуулагчдын тоо нэмэгдсэнээр хоолны зардал нэмэгдсэн, тус сувилал нь 2020 онд эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгалтад орж сайн үнэлэгдэж, магадлан итгэмжлэлийн эрхээ 3 жилээр сунгуулсантай холбогдуулж ажиллагсдаа 5.4 сая төгрөгөөр урамшуулсан зэрэг нь зардал хэтрэхэд нөлөөлсөн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу сувиллын эмнэлгийн барилга нь халдвар хамгааллын өрөө байхгүйгээс стандартын шаардлага хангахгүй байсан тул 11.1 сая төгрөгөөр халдвар хамгааллын өрөө, сувиллын машинд 5.9 сая төгрөгөөр гражийн барилга барих ажлуудыг аймгийн ОНӨГ-аас хууль журмын дагуу зөвшөөрөл авч, аж ахуйн аргаар гүйцэтгэж өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс зардлыг санхүүжүүлжээ.

3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс 144 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож тайлагнасан байна.

3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	8	53.8	8	53.8	100
Нийт дүн	8	53.8	8	53.8	100

/сая.төг/

3.10. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 29.2 сая төгрөгийн алдааг залруулж, 2.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Дахин үнэлсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг алдаатай оруулснаас үүссэн элэгдлийн зардал, хуримтлагдсан элэгдлийн тооцооллыг дахин хийж залруулав.
2. Бүх хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан шалгахад илүү дутуу тооцох, огт элэгдэл байгуулаагүй зэргээс 3.4 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсоныг залруулав.
3. Ашиглалтаас хасагдсан хөрөнгүүдийн хуримтлагдсан элэгдлийг зөрүүтэй хассан 0.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийг залруулав.
4. Ажилтнуудад 5.8 сая төгрөгийн урамшуулал олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, тайлагнаагүй, ХХОАТ-ын тайланд шууд бус орлогоор тайлагнасныг залруулав.
5. Дүрмийн санг 2016 онд өөрчилж, улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгасан бөгөөд түүнээс хойшхи хугацаанд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө болон акталсан хөрөнгүүдийн хөдөлгөөнөөр дүрмийн санг өөрчилсөн 23.3 сая төгрөгийн алдаатай бичилтийг залруулав.

3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сувиллын орлогыг бэлэн болон бэлэн бусаар авч, бэлэн орлогоо хуримтлуулан харилцах дансандаа тушаадаг. Бэлэн мөнгөний тайлан гаргадаггүйгээс хэдий хэмжээний орлогыг хуримтлуулж дансанд тушааж байгааг бүртгэлээр хянах хяналтгүй болгож байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3 “Нягтлан бодох бүртгэлийн ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.3.1 анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2 журналд бичих ...” заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Хөрөнгөнд тавих хяналт алдагдах

1.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн хуулийг хэрэгжүүлж, бэлэн мөнгөний тайлан гаргах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хүнсний материалын орлого зарлагын гүйлгээг тухай бүрд нь бүртгэдэггүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй, сар сараар нэгтгэн гаргадаг. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.1 аж ахуйн бүх ажил гүйлгээ” ... заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Бараа материал дутагдах

2.3. Өгсөн зөвлөмж

Худалдан авсан бараа материал, хөрөнгийн Е-баримтыг бүрэн авч, нягтлан бодогч шалгаж баталгаажуулан, гарсан ажил гүйлгээг тухай бүрд нь бүртгэж байх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

1.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Найдваргүй авлага үүсэх

3.3. Өгсөн зөвлөмж

Авлага өглөгийн үлдэгдэлд харилцагчидтай тооцоог нийлж актаар баталгаажуулах, хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

4. Балансын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Ажилтнуудад олгосон цалингаас НДШ, ХХОАТ суутгахдаа илүү дутуу суутгах, огт суутгахгүй зөрчил нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн "24.1 Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт албан татварын хөнгөлөлт үзүүлнэ", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17-р зүйлийн 1. "Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: 1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх; 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх;" заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Татварын тооцоолол буруу гарах

4.3. Өгсөн зөвлөмж

Татварын хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, алдааг залруулах.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ЫН 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2021			ДГА-2021/2/СТА-ААТҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ		мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Дахин үнэлсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг алдаатай оруулснаас элэгдлийн зардал, хуримтлагдсан элэгдэл алдаатай илэрхийлэгдсэн.	279.4	Залруулах	Нягтлан бодогч	Д.Баатар
2	Бүх хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан шалгахад илүү дутуу тооцох, огт элэгдэл байгуулаагүй зэргээс 3.4 сая төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон.	3,393.5	Залруулах	Нягтлан бодогч	Д.Баатар
3	Ашиглалтаас хасагдсан хөрөнгүүдийн хуримтлагдсан элэгдлийг алдаатай хасах, огт хасагдаагүй 0.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байна.	945.9	Залруулах	Нягтлан бодогч	Д.Баатар
4	Ажилтнуудад 5.8 сая төгрөгийн урамшуулал олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, тайлагнаагүй, ХХОАТ-ын тайланд шууд бус орлогоор тайлагнасан байна.	1,245.3	Залруулах	Нягтлан бодогч	Д.Баатар
5	Дүрмийн санг 2016 онд өөрчилж, улсын бүртгэлийн гэрчилгээндээ тусгасан бөгөөд түүнээс хойшхи хугацаанд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө болон акталсан хөрөнгүүдийн хөдөлгөөнөөр дүрмийн санг өөрчилсөн 23.3 сая төгрөгийн алдаатай бичилт гарсан.	23,330.4	Залруулах	Нягтлан бодогч	Д.Баатар
6	Сувиллын орлогыг бэлэн болон бэлэн бусаар авч, бэлэн орлогоо хуримтлуулан харилцах дансандаа тушаадаг. Бэлэн мөнгөний тайлан гаргадаггүйгээс хэдий хэмжээний орлогыг хуримтлуулж дансанд тушааж байгааг бүртгэлээр хянах хяналтгүй болгож байна.	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Баатар
7	Хүнсний материалын орлого зарлагын гүйлгээг тухай бүрд нь бүртгэдэггүй, дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй, сар сараар нэгтгэн гаргадаг. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.1 аж ахуйн бүх ажил гүйлгээ" заалттай нийцээгүй	-	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Баатар
8	1.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах	1,561.8	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Баатар

Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

	ажлыг зохион байгуулах, удирдах" заалттай нийцээгүй.				
9	Ажилтнуудад олгосон цалингаас НДШ, ХХОАТ суутгахдаа илүү дутуу суутгах, огт суутгахгүй зөрчил нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн "24.1 Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт албан татварын хөнгөлөлт үзүүлнэ", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17-р зүйл заалттай нийцэхгүй	1,100.3	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Д.Баатар
ДҮН		31,856.6			